



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/90

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, 2022 онд ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн аймгийн “Аварга малчин”, “Аварга тариаланч”, “Аварга саальчин”-аар шалгарсан иргэдийг шагнах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичиг	Б.Мөнхжаргал	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга
	Д.Цогтбаатар	Хан хэнтий чуулгын дарга
	Г.Гантөмөр	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга
	Г.Оюун-Эрдэнэ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

2.Арга хэмжээг удирдлагаар хангаж, өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ